

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/72/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:
davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунтуяа

Утас: 99036832 Цахим хаяг:
ariuntuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН БАЯНЗҮРХ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Г.ОДСЭР ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.25 № 01/285
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баянзүрх сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянзүрх сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Баянзүрх сумын ТТЗ-ийн хяналтад байгаа байгууллагуудын үндсэн хөрөнгө нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 31.2 сая төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр болон хандив тусламжаар 294.6 сая төгрөгийн нийт 325.9 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогоос 25.5 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогоос 4.6 сая төгрөг нийт 30.1 сая төгрөгийн орлого тасарсан, Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон 1 зээлдэгчтэй холбоотой 32.1 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Баянзүрх сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө 7 зорилтын 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, хэрэгжилтийг 94.4 хувьтай биелүүлж ажилласан байна.

6724040700

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

				/Мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		309,244.0	352,556.8	
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	201,534.6	243,258.9	
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	75,995.9	58,968.9	
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	31,713.5	50,329.0	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,833,956.4	3,829,688.0	
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	152,453.6	125,051.0	
37300	Урт хугацаат зээл		152,453.6	125,051.0	
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,681,502.8	3,704,637.0	
39200	Биет хөрөнгө		3,654,802.0	3,678,155.6	
39300	Биет бус хөрөнгө	13	26,700.8	26,481.4	
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		4,143,200.4	4,182,244.8	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,143,200.4	4,182,244.8	
51	Засгийн газрын хувь оролцоо		4,143,200.4	4,182,244.8	
51100	Засгийн газрын оруулсан капитал		327,386.9	327,386.9	
51200	Хуримтлагдсан үр дүн		3,293,235.5	3,332,279.9	
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		522,578.0	522,578.0	
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		4,143,200.4	4,182,244.8	

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				/Мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		1,236,378.0	1,549,603.3	
11	ТАТВАРЫН ОРЛОГО		392,034.9	475,190.8	
110	Орлогын албан татвар		218,153.0	282,088.1	
1100	Хувь хүний орлогын албан татвар		227,565.0	290,615.2	
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-9,412.0	-8,527.2	
113	Хөрөнгийн албан татвар		71,352.0	88,893.2	
118	Бусад татвар, төлбөр, хураамж		102,530.0	104,209.5	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	173,705.4	212,689.0	
120	Нийтлэг татварын бус орлого		173,705.4	212,689.0	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		670,637.7	861,723.4	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,128,630.8	1,507,315.5	
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,128,630.8	1,507,315.5	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		958,566.5	1,223,428.9	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		413,153.3	498,909.9	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		52,536.1	62,784.4	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		135,785.7	34,963.3	
2104	Хангамж, бараа материалын зардал		34,686.9	59,094.1	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		26,488.6	7,105.5	
2107	Томиллолт, зочны зардал		2,770.0	7,558.0	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		29,388.9	223,504.8	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		263,757.1	329,508.9	

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		170,064.2	283,886.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		107,747.2	42,287.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		6,657,777.0	3,243.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-6,550,029.8	39,044.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,131,217.0	1,394,389.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	392,034.9	475,190.8
110	Орлогын албан татвар	218,153.0	282,088.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	227,565.0	290,615.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-9,412.0	-8,527.2
113	Хөрөнгийн албан татвар	71,352.0	88,893.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	102,530.0	104,209.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,832.2	4,948.2
1181	Газрын төлбөр	7,042.6	13,809.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	89,655.2	85,452.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,544.4	57,475.3
120	Нийтлэг татварын бус орлого	68,544.4	57,475.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	670,637.7	861,723.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,018,145.8	1,321,428.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,018,145.8	1,321,428.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	717,586.4	942,271.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	413,246.8	498,909.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,418.8	62,784.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135,448.4	36,250.0
2104	Хангамж, бараа материалын зардал	34,080.9	53,537.8
2105	Нормативт зардал	0.0	1,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,829.6	16,600.7
2107	Томилолт, зочны зардал	2,770.0	7,558.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,655.3	232,496.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,136.7	33,134.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,559.3	379,156.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	113,071.2	72,961.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	10,252.0	31,237.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,252.0	31,237.0
2200	Дотоод эх үүсвэрээр	10,252.0	31,237.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-10,252.0	-31,237.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-47,180.8	41,724.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	248,715.4	201,534.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	201,534.6	243,258.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,746,316.3	10,746,316.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-53,086.2	-53,086.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,693,230.2	10,693,230.2
9	Тайлант үеийн үр дүн	-6,550,029.8	-6,550,029.8
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,143,200.4	4,143,200.4
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,143,200.4	4,143,200.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,143,200.4	4,143,200.4
19	Тайлант үеийн үр дүн	39,044.5	39,044.5
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,182,244.8	4,182,244.8

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,577,214.1	1,337,960.9	(239,253.2)	84.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,485,552.8	1,337,960.9	(147,591.9)	90.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	970,548.2	960,439.9	(10,108.3)	99.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	505,114.0	498,909.9	(6,204.1)	98.8
210101	Үндсэн цалин	481,936.8	358,107.6	(123,829.2)	74.3
210102	Нэмэгдэл	19,177.2	117,963.7	98,786.5	615.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	7695	7695	
210104	Урамшуулал	4,000.0	15,143.6	11,143.6	378.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,621.6	62,784.4	(1,837.2)	97.2
210201	Тэтгэврийн даатгал	43,547.0	42,298.4	(1,248.6)	97.1
210202	Тэтгэмжийн даатгал	4,667.5	4,520.7	(146.8)	96.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,792.0	4,674.5	(117.5)	97.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,077.7	1,047.1	(30.6)	97.2
210205	Эрүүл мэндийн даатгал	10,537.4	10,243.6	(293.8)	97.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	197,119.0	196,297.8	(821.2)	99.6

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	57,318.0	54,865.6	(2,452.4)	95.7
210302	Түлш, халаалт	132,401.0	132,740.6	339.6	100.3
210303	Цэвэр, бохир ус	7,400.0	8,691.7	1,291.7	117.5
2104	Хангамж, бараа материалын зардал	50,592.7	50,267.2	(325.5)	99.4
210401	Бичиг хэрэг	7,378.0	7,377.5	(0.5)	100.0
210402	Тээвэр, шатахуун	33,389.9	33,389.9	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,400.0	3,075.0	(325.0)	90.4
210404	Ном, хэвлэл	6,424.8	6,424.8	-	100.0
2105	Нормативт зардал	1,000.0	1,000.0	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000.0	1,000.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,655.2	58,177.3	(477.9)	99.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,532.7	15,532.7	-	100.0
210602	Тавилга	12,122.5	11,993.5	(129.0)	98.9
210604	Урсгал засвар	31,000.0	30,651.1	(349.0)	98.9
2107	Томилолт, зочны зардал	7,350.0	6,908.0	(442.0)	94.0
210702	Дотоод албан томилолт	7,350.0	6,908.0	(442.0)	94.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,863.2	53,862.9	(0.3)	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51,559.2	51,559.2	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,209.6	1,209.6	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	108.9	108.9	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149.3	149.3	(0.0)	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	91.2	91.1	(0.1)	99.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600.0	600.0	-	100.0
210807	Газрын төлбөр	145.0	144.8	(0.2)	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,232.5	32,232.5	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,532.5	20,532.5	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,700.0	11,700.0	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	515,004.6	377,521.0	(137,483.6)	73.3

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	448,091.8	310,608.2	(137,483.6)	69.3
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	448,091.8	310,608.2	(137,483.6)	69.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,912.8	66,912.8	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,168.0	21,168.0	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,744.8	45,744.8	-	100.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	91,661.3		- (91,661.3)	-
230001	Эргэж төлөгдөх зээл	91,661.3		- (91,661.3)	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,577,214.1	1,422,356.5	(154,857.6)	90.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	284,032.4	276,032.4	(8,000.0)	97.2
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	284,032.4	276,032.4	(8,000.0)	97.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,024,858.8	1,096,471.6	71,612.8	107.0
320001	Орон нутгийн төсвөөс	1,024,858.8	1,096,471.6	71,612.8	107.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	268,322.9	49,852.5	(218,470.4)	18.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,296.5	44,145.5	(26,151.0)	62.8
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,209.3	5,707.0	(502.3)	91.9
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	191,817.1		- (191,817.1)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	35026.74375	35026.74375	#DIV/0!
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	110149.7678	110149.7678	#DIV/0!

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,868.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,868.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,068.6
2104	Хангамж, бараа материалын зардал	3,270.6
210401	Бичиг хэрэг	1,319.0
210402	Тээвэр, шатахуун	1,951.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,246.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,246.0
2107	Томилолт, зочны зардал	650.0
210702	Дотоод албан томилолт	650.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	902.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	434.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	468.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800.0

2132	Бусад урсгал шилжүүлэг	800.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,868.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,868.6
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,146.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,677.6
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5245

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 3 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 сан түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 57.6 сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Баянзүрх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 12.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн. 2.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 9.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгсөн байна.

Баянзүрх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 12.1 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн бөгөөд тогтоосон материаллаг түвшнээс хэтрээгүй тул зөрчилгүй дүгнэлт өгсөн болно.

5.1 Төлбөрийн акт

ТТЗ-ийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

ТТЗ-ийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар албан шаардлага хүргүүлээгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн үлдэгдэлтэй 17 зээлдэгчийн нийт 32.1 сая төгрөгийн зээлийг барагдуулаагүй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021оны 361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.2.1.“орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах

2. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл 6 нэр төлийн нийт 25.5 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын дотоод бараа үйлчилгээний НӨАТ-ийн орлого 4.6 сая төгрөгөөр нийт 30.1 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1.“хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн

төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд Эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь гүйцэтгэлийг хангаж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	1	30.1					1	30.1				
Хугацаа хэтэрсэн зээлийн авлага	1	32.1					1	32.1				
Дүн	2	62.2					2	62.2				
Харьяа байгууллагуудын зөрчил /ЗДТГ/												
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	2,960.0	1	2,960.0								
Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй	1	9,181.6			1	9,181.6						
Дүн	2	12,203.6	1	2,960.0	1	9,181.6						